

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2007 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

“Даатгалын мэргэжлийн оролцогчийн нягтлан бодох
бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн тайлангийн
агуулга, маягтыг тогтоох журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. ”Даатгалын мэргэжлийн оролцогчийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, орлогын тайланг 2, Даатгалын зуучлалын компанийн гэрээний бүртгэлийг 3, Даатгалын үнэлгээний компанийн бүртгэлийг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН НЯГТЛАН
БОДОХ БҮРТГЭЛИЙН БАРИМТ БИЧИГ, САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АГУУЛГА, МАЯГТЫГ ТОГТООХ ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6.2.3-д заасны дагуу даатгалын мэргэжлийн оролцогчийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн тайлангийн агуулга, маягтыг тогтоож мөрдүүлэхэд энэ журмын зорилго оршино.

1.2. Энэ журам нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон түүнтэй холбогдож гарсан заавар, журам, Монгол улсад мөрдөгдөж байгаа олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын хүрээнд мөрдөгдөнө.

**ХОЁР. Даатгалын мэргэжлийн оролцогчийн
үйл ажиллагааны орлогын тайлан**

2.1. Даатгалын зуучлагчийн орлого гэж даатгагч болон даатгуулагчийн олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө гэрээ, хэлцэл хийх этгээдтэй холбон өгөх, үүнийхээ төлөө авсан хөлсийг хэлнэ.

2.2. Даатгалын төлөөлөгчийн шимтгэл гэж даатгагчийн хууль ёсны эрх ашиг сонирхлын нэрийн өмнөөс хэлцэл болон эрх зүйн бусад үйлдэл хийх, үүнийхээ төлөө даатгагчаас авсан хөлсийг хэлнэ.

2.3. Даатгалын хохирол үнэлэгчийн орлого гэж даатгагч болон даатгуулагчийн нэрийн өмнөөс даатгалын гэрээтэй холбоотой хохирлын нэхэмжлэлийг хянан шалгах, бодит хохирлыг тогтоох, талуудын хооронд хэлэлцээ хийх чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх, ийнхүү хэрэгжүүлсний төлөө авсан хөлсийг хэлнэ.

2.4. Даатгалын зуучлагчийн болон хохирол үнэлэгчийн орлогыг Сангийн сайдын 2004 оны 248 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан орлогын тайланд бичнэ.

2.5. Даатгалын төлөөлөгчийн шимтгэлийг Даатгагч Сангийн сайдын 2004 оны 248 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан орлогын тайлангийн үйл ажиллагааны зардал хэсэгт бичнэ.

ГУРАВ. Орлогын тайлангийн маягтын агуулга, хэлбэр

3.1. Сангийн сайдын 2004 оны 248 дугаар тушаалаар 2 дугаар хавсралтаар баталсан орлогын тайланд зуучлал, үнэлгээний үйл ажиллагааны орлогыг бичнэ.

3.2. Даатгалын зуучлагч компани орлогын тайланг энэ журмын 1 дүгээр хавсралтаар гаргана.

3.3. Даатгалын үнэлгээний компани орлогын тайланг энэ журмын 2 дугаар хавсралтаар гаргана.

3.4. Даатгалын зуучлагч компани зуучлалын үйл ажиллагааны талаарх мэдээллийг 3 дугаар хавсралтаар гаргана

3.5. Даатгалын үнэлгээний компани үнэлгээний үйл ажиллагааны талаарх мэдээллийг 4 дүгээр хавсралтаар гаргана

3.6. Даатгалын зуучлагч болон үнэлгээний компани улирал бүр 3, 4 дүгээр хавсралтын мэдээг санхүүгийн тайлангийн хамт Хороонд ирүүлнэ.

ДӨРӨВ. Бусад

4.1. Даатгалын зуучлагч компани нь даатгуулагчаас даатгагчид төлөх даатгалын хураамжийн орлогоос 10 хүртэл хувиар зуучлалын хөлс авч болно.

4.2. Даатгалын үнэлгээний компани хохирлын нөхөн төлбөрийн дүнгээс 5 хүртэл хувиар үйлчилгээний хөлс авч болно.

4.3. Даатгалын зуучлагч болон үнэлгээний компани даатгагч, даатгуулагчтай байгуулсан зуучлалын гэрээний дагуу үйл ажиллагаа явуулах үүргийг хүлээнэ.

4.4. Даатгалын зуучлагч нь даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлгүй этгээдэд зуучилж орлого олохыг хориглоно.

--ooOoo--

Даатгалын мэргэжлийн оролцогчийн нягтлан
бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн
тайлангийн агуулга, маягтыг тогтоох журмын
нэгдүгээр хавсралт

ОРЛОГЫН ТАЙЛАН

200... оны ... сарынөдөр

(Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	(төгрөгөөр)
			Тайлант жилийн дүн
1.1.1	Даатгагчид төлөгдсөн даатгалын хураамжийн орлогын дүн		
1.1.2	Даатгагчид зуучилсан орлого		
1.1.3	Даатгуулагчид зуучилсан орлого		
1.1.4	Даатгалын хохирлын зуучлалын орлого		
1.1.5	Бусад үйл ажиллагааны орлого		
1.1.6	Нийт орлого		

Захирал / /

Нягтлан бодогч / /

Даатгалын мэргэжлийн оролцогчийн нягтлан
бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн
тайлангийн агуулга, маягтыг тогтоох журмын
хоёрдугаар хавсралт

ОРЛОГЫН ТАЙЛАН

200... оны ... сарынөдөр

_____ (Аж ахуйн нэгж байгууллагын нэр)

(төгрөгөөр)			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1.1	Даатгалын хохирлын үнэлгээний орлого		
1.1.2	Бусад орлого		
1.1.3	Нийт орлого		

Захирал /

Нягтлан бодогч /

Даатгалын мэргэжлийн оролцогчийн нягтлан
 бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн
 тайлангийн агуулга, маягтыг тогтоох журмын
 гуравдугаар хавсралт

Даатгалын зуучлагч компанийн гэрээний бүртгэл

(төгрөгөөр)

д/д	Даатгуулагчийн нэр	Гэрээний дугаар	Даатгалын хэлбэр	Даатгалын үнэлгээ	Даатгалын хураамжийн хувь хэмжээ	Даатгалын хураамжийн нийт дүн	Зуучлалын хувь хэмжээ	Зуучлалын орлогын дүн	Даатгагчийн нэр
1									
2									
3									
4									
	Дүн								

Захирал / /

Нягтлан бодогч / /

Даатгалын мэргэжлийн оролцогчийн нягтлан
бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн
тайлангийн агуулга, маягтыг тогтоох журмын
дөрөвдүгээр хавсралт

Даатгалын үнэлгээний компанийн бүртгэл

№	Хохирол үнэлүүлэгчийн нэр	Даатгагчийн нэр	Даатгалын хэлбэр	Хохирлын нийт дүн	Шимтгэлийн хувь хэмжээ	Шимтгэлийн орлогын дүн

Захирал / /

Нягтлан бодогч / /